



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/021/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Сугармаа

Утас: 70273204 Цахим хаяг: [Sugarmaag@audit.gov.mn](mailto:Sugarmaag@audit.gov.mn)

АГУУЛГА

---

- 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....
- 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....
- 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....
- 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Б.ГОМБОДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 15 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 7 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,764,993.2 мянган төгрөгөөр баталснаас 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 106,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,871,493.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,084,982.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 213,488.8 мянган төгрөгөөр буюу 11,4 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Жаргалант сумын Засаг дарга аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2025 онд нийт 8 зорилт, 180 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дэвшүүлэн ажилласнаас 137

зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 8 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 24 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 11 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 89,4 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,680,563.13	2,041,355.07
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,114,996.09	1,455,416.01
3	1.1.3 АВЛАГА	318,414.81	315,784
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	247,152.22	270,155.06
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,618,918.29	6,250,261.82
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,618,918.29	6,250,261.82
7	1.2.2.02 Биет хөрөнгө	5,129,133.89	5,760,931.42
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	489,784.4	489,330.4
9	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>7,299,481.41</b>	<b>8,291,616.89</b>
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,979.38	358,125.53
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,979.38	358,125.53
12	2.1.1.03 Өглөг	19,979.38	358,125.53
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,279,502.03	7,933,491.36
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	7,279,502.03	7,933,491.36
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	471,343.58	471,343.58
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	6,096,845.59	6,751,553.4
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	711,312.87	710,594.38
18	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>7,299,481.41</b>	<b>8,291,616.89</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,299,580.86	4,253,249.01
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,934,557.98	1,883,082.89
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,463,587.11	1,539,516.22
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	1,463,587.11	1,539,516.22
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	107,591.31	123,975.94
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	363,379.56	219,590.74
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,892,153	2,370,166.12
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	596,422.47
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,472,869.87	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,729,671.74	3,600,596.06
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,483,441.65	2,887,550.92
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,455,713.97	2,851,572.77
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,829.92	959,483.91
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,511.94	119,365.35
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	785,014.9	859,163.84
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	51,953.58	65,229.13
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал	259,953.59	261,527.97
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	31,389.85	31,394.6
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	7,759	4,999
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,160.41	14,375.67
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	399,140.8	536,033.3
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,727.68	35,978.14
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	246,230.09	713,045.15
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,569,909.12	652,652.94
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,129.41	2,663
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-85,129.41	-2,663

<b>Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан</b>			
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,484,779.71	649,989.94

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,862,880.86	3,609,237.55
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,934,557.98	1,883,082.89
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,463,587.11	1,539,516.22
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	107,591.31	123,975.94
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	363,379.56	219,590.74
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,687.07	22,711.11
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	314,013.11	167,974.42
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	26,679.38	28,905.21
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,453.01	1,726,154.66
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	455,453.01	603,197.09
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	596,422.47
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	526,535.1
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,472,869.87	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,129,722.45	2,423,041.52
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,129,722.45	2,423,041.52
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,101,482.3	2,386,985.35
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	796,231.37	953,750.25
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,689.84	119,365.35
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	784,766.9	852,399.04
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	50,639.91	45,103.64
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	268,185.78	302,297.05
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	33,605.75	35,552.5
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,759	4,999
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,884.78	13,630.92
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	34,718.97	59,887.6
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,240.15	36,056.17
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,733,158.42	1,186,196.03
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,251,830.02	795,070.91
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,251,830.02	795,070.91
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,251,830.02	795,070.91
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,251,830.02	-795,070.91
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	459.5	50,705.2
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-459.5	-50,705.2
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	480,868.89	340,419.92
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	634,127.19	1,114,996.09
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,114,996.09	1,455,416.01

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,794,722.32	0	4,794,722.32
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,794,722.32	0	4,794,722.32
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	2,484,779.71	0	2,484,779.71
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,279,502.03	0	7,279,502.03
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,279,502.03	0	7,279,502.03
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,717.86	0	4,717.86

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан				
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,284,219.9	0	7,284,219.9
8	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-718.49	0	-718.49
9	1.7 Тайлант үеийн үр дүн	649,989.94	0	649,989.94
10	1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,933,491.36	0	7,933,491.36

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,273,872.20</b>	<b>5,111,108.61</b>	<b>162,763.59</b>	<b>96.9</b>
11	3.1.01.1.1 Татварын орлого	1,731,493.20	1,883,082.89	(151,589.69)	108.8
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	1,391,353.20	1,539,516.22	(148,163.02)	110.6
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	125,280.00	123,975.94	1,304.06	99.0
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	214,860.00	219,590.74	(4,730.73)	102.2
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,000.00	22,711.11	(2,711.11)	113.6
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	166,000.00	167,974.42	(1,974.42)	101.2
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	28,860.00	28,905.21	(45.21)	100.2
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,542,379.00	3,228,025.71	314,353.29	91.1
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	343,000.00	279,356.43	63,643.57	81.4
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,669,020.80	2,422,134.18	246,886.62	90.7
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	530,358.20	526,535.10	3,823.10	99.3
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,765,199.70</b>	<b>2,735,505.63</b>	<b>1,029,694.07</b>	<b>72.7</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,562,302.20</b>	<b>1,974,889.38</b>	<b>587,412.82</b>	<b>77.1</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,523,344.20</b>	<b>1,938,833.21</b>	<b>584,510.99</b>	<b>76.8</b>
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	889,044.70	851,076.29	37,968.41	95.7
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,515.30	106,747.24	4,768.06	95.7
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	926,020.40	852,399.04	73,621.36	92.0
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	50,889.90	36,000.05	14,889.85	70.7
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	2,990.00	1,519.00	1,471.00	50.8
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	44,000.00	32,454.50	11,545.50	73.8
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	9,500.00	4,999.00	4,501.00	52.6
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,010.80	9,050.50	36,960.31	19.7
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	443,373.10	44,587.60	398,785.50	10.1
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,958.00</b>	<b>36,056.17</b>	<b>2,901.83</b>	<b>92.6</b>
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	38,958.00	36,056.17	2,901.83	92.6
<b>22</b>	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>999,897.50</b>	<b>709,911.05</b>	<b>289,986.45</b>	<b>71.0</b>
<b>23</b>	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>203,000.00</b>	<b>50,705.20</b>	<b>152,294.80</b>	<b>25.0</b>
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,093,338.42		
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,445,571.01		
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	88.00	84.00	4.00	95.5
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.0
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	41.00	2.00	95.3
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43.00	41.00	2.00	95.3

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>374,211.30</b>	<b>196,778.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>129,223.10</b>	<b>120,218.64</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,495.10	120,218.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,694.70	101,440.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,415.40	12,618.06
2104	Хангамж, бараа материалын зардал	5,141.50	5,159.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	850	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,956.60	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,236.90	1,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,728.00</b>	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,510.00	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,218.00	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>244,988.20</b>	76,559.86
2200	Дотоод эх үүсвэрээр	244,988.20	76,559.86
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>374,211.30</b>	<b>197,658.66</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	374,211.30	197,658.66
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	<b>880.16</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

#### Залруулсан алдаа байхгүй.

### 5.2. Залруулаагүй алдаа

Залруулагдаагүй нийт 218,067.5 мянган төгрөгийн зөрчлөөс 8,960.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,999.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 218,067.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 албан шаардлага өгөв.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй болно.

#### 5.2 Албан шаардлага

1.Өмнөх оны аудитаар “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Өгөөмөр 2-р багт байрлах хогийн цэгийг нүх ухаж, хашаажуулах, тохижуулах ажил хийхээр Чамин хаус ХХК-тай 44,800.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, 2021 оны 10 дугаар сарын 04-нд урьдчилгаа 50,0 хувь болох 22,400.0 мянган төгрөг, 2021 оны 11 дүгээр сарын 03-нд явцын санхүүжилт болох 13,440.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд нийт гэрээний үнийн дүнгийн 80,0 хувийг тухайн аж ахуйн нэгжид шилжүүлсэн байна. Гэвч тайлант онд үлдсэн 20,0 хувийн ажил болох агуулахын барилгын цонх, хаалгыг хийж гүйцэтгэж дуусгалгүй өнөөдрийг хүрсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5.-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 173,923.1 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 4 нэр төрлийн орлогыг 35,184.4 мянган төгрөгөөр, нийт 209,107.5 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.8-д “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Засаг дарга	1	1			1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Засаг даргын тамгын газар	1	1			1			
4	Ойн анги	1		1					
5	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	Эмийн эргэлтийн сан	1		1					
7	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
8	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>6</b>		<b>2</b>			

### 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Засаг даргын Тамгын газар</b>	<b>5</b>	<b>507,907.7</b>	<b>1</b>	<b>11,961.5</b>	<b>4</b>	<b>495,946.2</b>	<b>5</b>	<b>507,907.7</b>		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>507,907.7</b>	<b>1</b>	<b>11,961.5</b>	<b>4</b>	<b>495,946.2</b>	<b>5</b>	<b>507,907.7</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил				Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Засаг дарга</b>	<b>2</b>	<b>218,067.5</b>			<b>2</b>	<b>218,067.5</b>		
<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</b>	<b>2</b>	<b>0</b>					<b>2</b>	<b>0</b>
<b>Засаг даргын тамгын газар</b>	<b>3</b>	<b>57,267.3</b>			<b>2</b>	<b>57,267.3</b>	<b>1</b>	<b>0</b>
<b>Хоршоо хөгжүүлэх сан</b>	<b>1</b>	<b>104,096.5</b>			<b>1</b>	<b>104,096.5</b>		
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>379,431.3</b>			<b>5</b>	<b>379,431.3</b>	<b>3</b>	<b>0</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)